

Чех улсад бүтэн цагаар ажиллах тохиолдолд долоо хоногт 40 цаг гэж тогтоосон байдаг. Хагас цагаар ажиллах тохиолдолд долоо хоногт ажиллах цаг багасдаг. Үүний зэрэгцээ цалин, амралт авах эрх эсвэл бусад тэтгэмжүүд багасгана. Ажил эхлэх болон дуусах цагийг ажил олгогч өөрөө шийднэ. Хэрвээ ээлжийн ажилтай бол багадаа 14 хоногийн өмнө ээлжийн хуваарийг өгсөн байх ёстой.

- Хоёр эсвэл гурван ээлжийн ажлын журам - нэг өдрийн дотор 12 эсвэл 8 цагийн дараа ээлж солигдоно.
- Урт эсвэл богино долоо хоногийн ажлын ээлжүүд - энэ нь нэг долоо хоногт илүү олон өдөр (ихэвчлэн даваа, мягмар, баасан, бямба, ням гарагт), дараагийн долоо хоногт цөөн өдөр (ихэвчлэн лхагва, пүрэв гарагт) ажиллана гэсэн үг юм.

Зарим ажил олгогчид уян хатан ажлын цаг эсвэл homeoffice санал болгож болно:

УЯН ХАТАН АЖЛЫН ЦАГ – ажил эхлэх болон дуусах цагийг ажил олгогчийн тогтоосон цагийн хуваарийн дагуу ажилтан өөрөө цагаа тогтоно. Жишээлбэл, хэрэв ажил олгогч таныг 10:00-14:00 цагийн хооронд ажил дээрээ байх ёстой гэж тогтоосон бол 8:00 эсвэл 10:00 цагт ажилдаа ирэх эсэх нь танаас шалтгаална. Мэдээжийн хэрэг, ажлын цаг дуусах хугацаа нь таны ажиллах цагийн хэмжээгээр сунгагдана.

ШАХСАН АЖЛЫН ДОЛОО ХОНОГ - үргэлж ажил олгогчтой тохиролцсоны үндсэн дээр байна. Бодит байдал дээр энэ нь 5 хоногийн оронд 4 өдөр ажиллаад, долоо хоногийн ажлын цагаа энэ 4 хоногт л гүйцэтгэх ёстой. Тэгэхээр долоо хоногт 40 цаг ажиллах ёстой бол 10 цагаар долоо хоногийн 4 өдөрт ажиллах боломжтой юм.

HOMEOFFICE – ГЭРЭЭС АЖИЛЛАХ – хийж буй ажлын төрөл болон ажил олгогчтой үргэлж тохиролцсон байна. Homeoffice гэдэг нь гэрээсээ ажиллана гэсэн үг. Ажил олгогч таныг homeoffice авч болох эсэх мөн хэр олон удаа авч болохыг тодорхойлно. Гэрээсээ ажиллаж байгаа ч гэсэн хөдөлмөр хамгаалах (BOZP) дүрэм журмыг дагаж мөрдөх ёстой.

Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах эсвэл чөлөө авах үед ямар эрхтэй вэ?

- Хэрвээ та шөнийн цагаар, амралтын өдөр эсвэл бүх нийтийн амралтын өдөр ажилладаг бол **нэмэлт цалин авах эрхтэй**.
- Хэрэв та илүү цагаар ажилладаг бол ажил олгогчтой тохиролцсоны үндсэн дээр **цалингүй амралт** авч болно. Жишээлбэл, та 2 цаг илүү ажилласан бол маргааш нь 2 цагийн өмнө гэртээ харьж болно.
- Хэрэв та өвдсөн бол „*neschopenka*“ авах эрхтэй - хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан гэх магадлалыг эмч олгоно. Тиймээс өвчтэй үедээ та ажилдаа явж болохгүй. Та өвчний тэтгэлэг авах эрхтэй бөгөөд өөрөөр хэлбэл цалингаа хувилж авна.
- Хэрэв та эмчид үзүүлэх шаардлагатай бол эмчээр баталгаажуулсан **чөлөөлөх** хуудсаа ажилдаа өгнө. Тиймээс та эмчийн үзүүлсэн цагаа нөхөж ажиллах шаардлагагүй.
- Хэрэв таны асран халамжилж буй хүүхэд өвчтэй бол ОЃР буюу гэр бүлийн гишүүн асран сувилах („*ošetřovačka*“) гэрчилгээ гаргаж, ажил дээрээ хүлээлгэн өгч, гэртээ үлдэх боломжтой. Та цалингийнхаа тодорхой хэсгийг авах эрхтэй.
- Хэрэв таны бие тавгүй байгаа бол **sick days** буюу өвчнөө эдгэрэхэд зориулсан өдрийг сонгож болно. Энэ боломжийг бүх ажил олгогчид санал болгодоггүй. Энэ танд өгөх эсэх, хэрвээ өгвөл хэдэн хоног өгөх нь ажил олгогчтой хийсэн хэлэлцээрээс шалтгаална. Хэрэв та энэ өдрийг сонгосон бол эмчээс магадлалаа авах шаардлагагүй.